



НИЙСЛЭЛИЙН
ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

**АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **Албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх**

Төслийн дугаар: **НХААГ-20/0020**

Улаанбаатар
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-20/0020

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 10 цаг 30 минут**-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 11 цаг 00 минут**-д нээнэ.

Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810**

www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендерт оролцогчдын эрх бүхий болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлоход дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах этгээд:</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерээ электрон хэлбэрээр буюу “PDF” форматаар гаргацтай, тод хөрвүүлж илгээх, ингэхдээ өөрийн санал болгож буй тендерийн үнэ, хүчинтэй хугацаа болон холбогдох бусад мэдээллийг системийн холбогдох талбарт бүрэн оруулсан байх зэрэг хуулийн 53.5.4-т заасны дагуу мэргэжлийн байгууллагаас тогтоосон бусад аргачлал, зааврыг баримталж тендер илгээх;</p> <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 10 дугаар давхар, 1012 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 3.1	<p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. 2. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 3. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталоги ирүүлнэ, (Каталоги дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ.) 4. Тухайн барааны ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулна, (Сургалтын хуваарийг бэлтгэж ирүүлэх) 5. Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Барааг нийлүүлсний дараах байнгын болон урсгал үйлчилгээний (засвар) хуваарийг бэлтгэж ирүүлнэ. <p>Баталгаат засварын хугацаа 1 жилээс багагүй байх шаардлагатай ба албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай.</p>

	<p>Баримт бичгүүд нь Монгол хэлнээс бусад хэл дээр байгаа тохиолдолд баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэн тухай бүрт хавсарган ирүүлнэ.</p> <p>Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>												
ТӨӨЗ 4.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.												
ТӨӨЗ 5.1	<p>Барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт: Шаардлагатай.</p> <p>Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p>												
ТӨӨЗ 5.2	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.												
ТӨӨЗ 6.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.												
ТӨӨЗ 7.1	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь CIP үнэ байна. Энэ үнэнд тээврийн зардал, даатгал, татвар, сургалт, суурилуулалт болон эцсийн цэг хүртэлх бусад бүх зардлууд багтсан байна.												
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцтай</p> <table border="1"> <thead> <tr> <th>Багцын дугаар</th> <th>Төсөл, арга хэмжээний нэр</th> <th>Төсөвт өртөг /төгрөгөөр/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>НХААГ-20/0020-1</td> <td>Хэвлэгч машин нийлүүлэх</td> <td>12,883,700</td> </tr> <tr> <td>НХААГ-20/0020-2</td> <td>Камержуулалт нийлүүлэх</td> <td>2,090,000</td> </tr> <tr> <td colspan="2">Нийт</td> <td>14,973,700</td> </tr> </tbody> </table>	Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /төгрөгөөр/	НХААГ-20/0020-1	Хэвлэгч машин нийлүүлэх	12,883,700	НХААГ-20/0020-2	Камержуулалт нийлүүлэх	2,090,000	Нийт		14,973,700
Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /төгрөгөөр/											
НХААГ-20/0020-1	Хэвлэгч машин нийлүүлэх	12,883,700											
НХААГ-20/0020-2	Камержуулалт нийлүүлэх	2,090,000											
Нийт		14,973,700											

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг
1	Багц-1 Хэвлэгч машин	<ul style="list-style-type: none"> • Konica Minolta Bizhub 458e түүнтэй дүйцэхүйц • Үндсэн функц: Хэвлэх, хувилах, сканердах, бүрэн автомат, А3-А5, хоёр талдаа хэвлэх, /хар, саарал/ • Сүлжээний холболт: 10/100/1000Base-T, USB2.0 (Hi-Speed) • Хэвлэх, хувилах хурд /1 мин/: А4: 45 хуудас, А3: 25 хуудас • Хэвлэх, хувилах нягтрал: 1200/1200 dpi • Сканер: Автомат татагч, цаасны ар өвөргүй • Сканнер нягтрал: 600 dpi • Цаасны оролт: А3, А4, А5, А6, В5 • Цаасны жин: 60-300 гр • Automat paper sensor: Тийм • Дэмжих үйлдлийн систем: Windows, MAC OS, Unix, Ubuntu • Тэжээлийн залгуур: Европ стандарт • Тэжээл: AC230V, 7A (50 to 60HZ) 	1
2	Багц-2 Камержуулалт	<ul style="list-style-type: none"> • Бичигч төхөөрөмж: Hikvision 8Ch NVR 8PoE DS- 7608NI-Q2/8P түүнтэй дүйцэхүйц • Үндсэн функц: Бичигч төхөөрөмж • Суваг: 8-аас багагүй • PoE: Тийм • Хатуу диск: 4TB-аас багагүй, SATA III • Дүрсний шахалт: H265h.264 • Video out: HDMI, VGA • Power Supply: 100-240VAC, 6.3A, 50-60HZ 	1
		<ul style="list-style-type: none"> • Дотор камер: Hikvision WDR IR Cube WiFi Camera H.265+ 4MP 2.8mm DS-2CD2443G0-iW түүнтэй дүйцэхүйц • Дуу бичигч: Дуу бичигчтэй • Нягтрал: 4MP-ээс багагүй • Дуран: 2.8мм, 130 хэмээс багагүй • Шөнийн харалт: 20м • Power Supply: 12V DC±_10%, PoE • Protocols: TCP/IP HTTPS, RSTP 	2
		<ul style="list-style-type: none"> • Дотор камер: Hikvision IR Fixed Dome Camera H.265+ 4MP 2.8mm, 4mm DS-2CD1143G0-I түүнтэй дүйцэхүйц • Дуу бичигч: Шаардлагагүй • Нягтрал: 4MP-ээс багагүй • Дуран: 2.8мм, 130 хэмээс багагүй • Шөнийн харалт: 20м • Power Supply: 12V DC±_10%, PoE • Protocols: TCP/IP HTTPS, RSTP 	3
		• Туслах бараа материал	
		• UTP CAT5E кабель	300м
• RJ45 толгой	20		

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>[Дугаар бичих]</i>	<i>[Барааны товч тодорхойлолтыг бичих]</i>	<i>[нэгжийн тоо ширхэгийг бичих]</i>	<i>[Хэмжих нэгжийг бичих]</i>	<i>[Бараа хүргэх газрын нэр]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>
1	Багц-1 Хэвлэгч машин	1	ширхэг	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	
2	Багц-2 Хяналтын камер /дотор/ IP	3	ширхэг	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	
3		2	ширхэг	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	
4		Хяналтын камерын бичигч төхөөрөмж /8 сувгийн/ PoE дэмждэг	1	ширхэг	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног

ХОЛБОГДОХ ҮЙЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэх дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцон, бараа нийлүүлэх хугацаатай уялдуулан тогтооно].

1		2	3	4	5	6
Нэр төрөл		Үйлчилгээний талаархи тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
Багц-1	Хэвлэгч машин	Суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	1	Ширхэг	Чингэлтэй дүүрэг, багаторуу 15, Самбуугийн гудамж, Нийслэлийн засаг захиргааны IV байр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	
Багц-2	Хяналтын IP камер /дотор/	Суурилуулах, хэвийн ажиллагаанд оруулах,	3	Ширхэг	Чингэлтэй дүүрэг, багаторуу 15, Самбуугийн гудамж, Нийслэлийн засаг захиргааны IV байр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	
	Хяналтын IP камер /дотор, дуу бичигчтэй/		2	Ширхэг		
	Хяналтын камерын бичигч төхөөрөмж /8 сувгийн/ PoE дэмждэг		1	Ширхэг		

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |

- 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Нийлүүлэгч нь захиалагчид багаж, тоног төхөөрөмжийг, угсарч, суурьлуулж, шалгаж, сургалт зохион байгуулж хүлээлгэн өгнө. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас томилогдсон ажлын комисс шалгаж хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
<ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;4) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1.1 Баталгаат засварын тусгай шаардлага.
Тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
<p>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) | 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна.
Алдангийн нийт дүн: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна. |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]